

**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ
ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 07 дугаар
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Б.Уянга, С.Эрдэнэбат, С.Эрдэнэболд нараас 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчид одоогийн хуулийн зохицуулалтаар урамшуулал авах болзолд “бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх” “нас барсан хүүхэд нь 1 ба түүнээс дээш настай байх” зэрэг нөхцөл тавигдаж байгаа нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийг зөрчиж, хүүхдийг насаар нь ялгаварлан гадуурхах нөхцөл бүрдүүлснийг засах, хүний эрхэм чанарыг хүндэтгэх төрийн үүргийг хангах шаардлагатай байгааг харгалзан хуулийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 04 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын хүрээнд Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталснаар улсын төсөвт 7,5 тэрбум төгрөгийн зардал шинээр үүснэ гэж хууль санаачлагчид үзжээ.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн санал авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Засгийн газраас тус хуулийн төслийг дэмжээгүй үндэслэл, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хуулийн төслийн хүрээ хязгаарт зөвхөн Монгол Улсад төрсөн хүүхдэд хамаарах талаар тусгасан үндэслэлийн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хуулийн төслийг хэлэлцэх хүрээнд хүүхдийн насны талаар үүсэж буй ойлголтын зөрүүг арилгах талаар санал хэлсэн.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 68.8 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Л.ЭНХНАСАН